

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/20/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг:
MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.00	0.00	0.00
Банканд байгаа бэлэн мөнгө	125.2	170.0	44.8
Дүн	125.2	170.0	44.8
Үүнээс: байгууллагаар харуулбал			
Орон нутгийн ерөнхий орлого	123.2	145.5	22.3
Хоршоо хөгжүүлэх сан	1.9	21.8	19.9
Орон нутгийн хөгжлийн сан	0.1	2.7	2.6
Нийт дүн	125.2	170.0	44.8

Эх сурвалж: Арбулаг сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт /-/
Хоршоо хөгжүүлэх сан	205.2	199.3	-5.9
Нийт дүн	205.2	199.3	-5.9

Эх сурвалж: Арбулаг сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.8	1.2	0.4
Засаг даргын Тамгын газар	129.5	148.3	18.8
Нийт дүн	130.3	149.5	19.2

Эх сурвалж: Арбулаг сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 4. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хоршоо хөгжүүлэх сан /Хувь хүмүүст олгосон зээл/	56.5	46.5	-10.0
Дүн	56.5	46.5	-10.0

Эх сурвалж: Арбулаг сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-/
Засаг даргын Тамгын газар	1,216.3	1,523.5	307.2
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	7.2	6.0	-1.2
Нийт дүн	1,223.5	1,529.5	306.0

Эх сурвалж: Арбулаг сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 6. Өр төлбөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-/
Засаг даргын Тамгын газар	0.1	0.0	-0.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.0	0.0	0.0
Нийт дүн	0.1	0.0	-0.1

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 107.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 107.8 сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

1.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 11 иргэнтэй холбоотой 82.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

2.1 Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 8 нэр төрлийн 87.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрөл бүрээр төлөвлөгөөг биелүүлж ажиллах.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	24.9					1	24.9				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	82.9					1	82.9				
Дүн	2	107.8					2	107.8				



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 01/284
танай _____ -ны № _____ -г

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АРБУЛАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ГАНТУЛГА
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Арбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 170.0 сая төгрөг болж, өмнөх оноос 44.8 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 199.3 сая төгрөг байна. Үүнээс 11 иргэний 82.9 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Арбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 7 зорилтын 139 хэрэгжүүлэн ажиллахаар Хөвсгөл аймгийн Засаг даргаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 77.4 хувь биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР